

13

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН АРГА ХЭРЭГСЛҮҮД

Д.Оюунцэцэг

Эдийн засаг цаашдаа тэнцвэртэй тогтвортой хөгжих үйл явцыг эдийн засгийн тогтворжилт гэдэг. Орчин үед эдийн засгийг тогтворжуулах үйл явц нь 2 үндсэн хэлбэрээр хэрэгжиж байна. Эдгээр нь:

- Мөнгөний болон Сангийн бодлогыг ашиглан макро эдийн засгийн нөхцлийг сайжруулах
- Цалин, үнийн түвшинд түр хугацааны хязгаарлалт, хяналт тавих хэлбэрүүд юм.

Энэ хөдөр хөтөлбөрийн эцсийн ижил бөгөөд макро эдийн засгийн цогц зорилгуудыг хангахад чиглэдэг. Эдгээр зорилгууд нь:

- Инфляцийн түвшинг бууруулах буюу хамгийн боломжит түвшинд барьж байх
- Төсвийн хөтөлбөрийн балансын тэнцвэржилтийг хангах, ажилгүйдлийг багасгах буюу ажил эрхлэлтийн түвшинг нэмэгдүүлэх
- Бодит орлогын өсөлтийг хангах.

Эдгээр тогтворжилтын гол элемент нь инфляцийг бууруулах явдал бөгөөд энэ нь мөнгөний бодлогоор дамжин хэрэгждэг. Мөнгөөр дамжуулан эдийн засгийн байдал буюу эдийн засгийн өсөлт, үнэ, төлбөрийн тэнцэл, ажилгүйдэл гэх мэт макро эдийн засгийн орчинд нөлөөлөх төв банкны үйл ажиллагааг мөнгөний бодлого гэнэ.

Шилжилтийн эдийн засагтай орнуудад мөнгөний бодлого юуны өмнө үндэсний валютын худалдан авах чадварыг тогтворжуулахад чиглэгддэг.

Мөнгөний бодлогын талаар эдийн засгийн шинжлэх ухааны гол урсгалуудын хувьд өөр өөр үзэл баримтлалтай байдаг.

Монетаристууд мөнгөний бодлогын үндсэн зорилго мөнгөний нийлүүлэлтийг зохицуулах явдал гэж байхад Кейнсийн талынхан хүү болон зээлийн эх үүсвэрийн хүрэлцээний асуудалд

илүү ач холбогдол өгдөг. Монетаристууд мөнгөний нийлүүлэлтийн өөрчлөлт нь үндэсний үйлдвэрлэлийн өсөлт бууралтад нөлөөлдөг гэж үзэж байхад Кейнсчүүд Засгийн газрын төсөв, санхүүгийн бодлого нь эдийн засагт үзүүлэх нөлөөгөөрөө төв банкны мөнгөний бодлогоос давуутай гэж үздэг. Эрдэмтдийн эдгээр үзэл баримтлал нь эдийн засгийн судалгаа хийсэн орчин нөхцөл, онцлогоос хамаарч амьдрал дээр эсрэг дүгнэлтэд хүрэх ч тохиолдол байдаг.

Харин Монгол банкны хувьд мөнгөний бодлогын талаарх онолын аливаа нэг туйлыг яг баримтлаагүй бөгөөд өөрийн орны онцлог байдалд тохируулан мөнгөний нийлүүлэлтийг зохицуулж, төгрөгийн тогтвортой байдлыг хангах зорилтыг хэрэгжүүлэхийг зорьж байгаа билээ. Хэрэв мөнгөний бодлогын зорилт нь олон зүйлд зэрэг чиглэгдвэл эцсийн эцэст нэг зорилтоос нөгөө зорилт руу шилжих улс төрийн шахалтанд мөнгөний бодлого орох эрсдэл учирч болно.

Мөн түүнчлэн мөнгөний бодлогын зорилтыг хангах үүргийг төв банк, Засгийн газар хоёрт хувааж үүрүүлбэл эцэстээ аль аль нь хариуцлагагүй байх нөхцлийг бүрдүүлнэ. Иймээс ч ихэнхи орон, ялангуяа манай төв банкны хуулинд "Төгрөгийн тогтвортой байдлыг хангах явдал бол төв банкны мөнгөний бодлогын үндсэн зорилт мөн" гэж заасан байдаг. Гэхдээ төв банк нь макро эдийн засгийн бусад зорилтыг хэрэгжүүлэх үүднээс өөрийн үндсэн зорилтын хүрээнд санхүүгийн зах зээл, банкны тогтолцооны тогтвортой байдлыг хангах замаар үндэсний эдийн засгийн тэнцвэртэй хөгжилд дэмжлэг үзүүлнэ.

Төв банк нь төрийн мөнгөний бодлогыг өөрийн мөнгөний нийлүүлэлтэд тавих хяналтын үүргээрээ дамжуулан хэрэгжүүлдэг. Учир нь Монгол банкны зорилтыг хэрэгжүүлэх болон эдийн засгийн тогтворжилтод нөлөөлөгч гол хүчин зүйл нь мөнгөний нийлүүлэлт болдог.

Төв банк нь мөнгөний нийлүүлэлтэд нөлөөлөхдөө хуулиар зөвшөөрөгдсөн арга хэрэгслүүдийг ашигладаг. Мөнгөний бодлого явуулах нь төрөөс баримталж байгаа мөнгөний бодлогын талаарх үндсэн чиглэл зорилгоос шалтгаалдаг ба үүнтэй уялдуулан төв банк нь мөнгөний

- Хатуу
- Зөөлөн бодлогыг сонгож хэрэгжүүлдэг.

Зах зээлийн эдийн засгийн нөхцөлд төв банкнаас явуулж буй мөнгөний нийлүүлэлтийг ихэсгэх бодлогыг мөнгөний зөөлөн бодлого гэнэ. Зөөлөн бодлогын гол зорилго нь хөрөнгө оруулалтыг дэмжих үндэсний нийт бүтээгдэхүүнийг өсгөх, банкны нөөцлөх хэрэгцээг бууруулж ажилгүйдлийг багасгахад чиглэгддэг. Гэхдээ энд үйлдвэрлэлийн бүтцийг шинэчлэх асуудлыг анхаарч үзэх ёстой. Эс тэгвэл нэгэнт техник технологи нь хуучирсан, өрсөлдөх чадваргүй, үр ашиг муутай үйлдвэрт хичнээн зээл олгоод ч үйлдвэрлэл өсөхгүй, харин зээлийн дарамтад орж, мөнгөний нийлүүлэлтийг ихэсгэх, улмаар үнийн өсөлтийг нэмэгдүүлэх шалтгаан болж байна.

Заавал байлгах нөөцийг ихэсгэх, зээлийн хүүг өндөрсгөх гэх мэт мөнгөний бодлогын арга хэрэгслийг ашиглан мөнгөний нийлүүлэлтийг багасгах Төв банкны үйл ажиллагааг мөнгөний хатуу бодлого гэнэ.

Уг бодлогын зорилго нь дотоодын үнийн өсөлтийг бууруулж төгрөгийн худалдан авах чадварыг тогтворжуулах буюу ханшны уналтыг хязгаарлахад чиглэгддэг. Мөнгөний бодлогын арга хэрэгслүүдийг мөнгөний нийлүүлэлтэд нөлөөлөх байдлаар нь:

- Шууд арга
- Шууд бус арга гэж авч үздэг.

Шууд аргад арилжааны банкны зээлийн үлдэгдэлд хязгаарлалт тогтоох, хадгаламжийн хүүгийн доод түвшинг тогтоож өгөх зэрэг аргууд орно. Банк, санхүүгийн системийн хөгжил сул, зах зээлийн нөхцөлд ажиллах чадвар хангалтгүй нөхцөлд шууд аргыг хэрэглэх нь илүү тохиромжтой. Гэвч удаан хугацааны туршид захиргааны аргаар банкны үйл ажиллагаанд

нөлөөлбөл дараах сөрөг дагаварыг авчирдаг. Үүнд:

1. Санхүүгийн эрүүл биш тогтолцоог бүрдүүлэх
2. Банкуудын төлбөрийн чадварт муугаар нөлөөлөх
3. Санхүүгийн капитал нь хүүгээрээ дамжин үр ашигтай хуваарилагдахад саад болох
4. Эдгээр нь эргээд мөнгөний бодлогод сөргөөр нөлөөлөх гэх мэт.

Мөнгөний бодлогын шууд бус аргад:

- Заавал байлгах нөөц
- Нээлттэй зах зээлийн гүйлгээ
- Хүүгийн нэгдсэн бодлого
- Төв банкны зээлжүүлэлт гэх мэт аргууд орно.

Мөнгөний бодлогын арга хэрэгслийг сонгох, тэдгээрээр дамжуулан бодлого явуулахдаа дараах зүйлүүдийг анхаарч үзэх шаардлагатай байдаг. Эдгээр нь:

1. Мөнгөний бодлогын арга хэрэгсэл нь нөлөөлөгч үзүүлэлттэйгээ нягт холбоотой байх
2. Бодлогын арга хэрэгслээс гадна тухайн үзүүлэлтэд нөлөөлөх гадаад нөлөөллийг тооцож тодорхойлсон байх
3. Мөнгөний бодлогын зорилго нь эдийн засгийн өмнө дэвшүүлж тавьсан зорилготой нягт уялдаатай байх зэрэг асуудлууд юм.

Манай орны хувьд УИХ-аас тодорхойлсон чиглэлийн дагуу Төв банкны мөнгөний бодлого нь дотоодын үнийн өсөлтийг бууруулж, төгрөгийн худалдан авах чадварыг цаашид тогтворжуулах зорилтыг хэрэгжүүлэхийн зэрэгцээ хадгаламж эзэмшигч, харилцагчдын банкинд итгэх итгэлийг бэхжүүлэхэд чиглэгдэж байгаа юм. Төв банк нь уг зорилтоо хэрэгжүүлэхийн тулд мөнгөний хатуу бодлогыг баримталж мөнгөний бодлогын шууд болон шууд бус аргуудыг хослуулан хэрэглэж иржээ. Учир нь төгрөгийн тогтвортой байдлыг хангах явдал нь өөр хоорондоо хамааралтай дотоод үнэ, төгрөгийн гадаад валютаар илэрхийлэгдэх ханшны тогтвортой байдлаар хангагдах учир эдийн засаг дахь мөнгөний тоо хэмжээг мөнгөний бодлогын арга хэрэгслүүдээр дамжуулан зохицуулдаг.

Санхүүгийн системийн хөгжлийн эхний шатанд мөнгөний бодлогын шууд бус арга хэрэгслийн хөгжил нь сул, санхүү банкны байгууллагуудын зах зээлд зохицон ажиллах чадвар хангалтгүй байсантай холбоотойгоор Монгол банк нь шууд аргуудыг 1993 оноос эхлэн мөрдүүлж байсан. Гэвч шууд аргыг удаан хугацааны туршид хэрэглэснээс зарим оронд тохиолдож байгаа санхүүгийн хямрал, эдийн засгийн сөрөг үр дагаварууд өөрийн оронд үүсэхээс сэргийлж шууд бус системийн уялдаа холбоо, мөнгөний нийлүүлэлтэд нөлөөлөх нөлөөллийг хүчтэй болгох замаар шууд арга хэрэгслээс татгалзах чиглэл баримтлан ажиллаж байна. Үүний дагуу 1996 оноос хадгаламжийн хүүгийн доод хэмжээг Монгол банкнаас тогтоодог системийг өөрчилснөөр банкуудын хоорондын чөлөөт өрсөлдөөн нэмэгдэж, актив пассивын удирдлага сайжрахад эерэг нөлөөлөл шүзүүлж байна.

Мөн түүнчлэн банкуудаас банкны бус байгууллагад олгох зээлийн өрийн үлдэгдэлд хязгаарлалт тогтоодог системийг өөрчилж, төв банкны хууль болон төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлд заасны дагуу зарим банкинд зээлийн эх үүсвэр, санхүү төлбөрийн чадварыг харгалзан Монголбанкнаас тогтоосон заавал байлгах нөөцийн хэмжээг тогтвортой хангах хүртэл хугацаанд өрийн үлдэгдэлд нь хязгаарлалт тогтоох чиглэл баримтлах болсон.

Сүүлийн жилүүдэд Төв банк нь мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхдээ Төв банкны үнэт цаасны бодит хүүг эерэг байлгах зарчмыг баримтлан уян хатан тогтоож, үнэт цаасны зээл, хямдруулалтаар дамжуулан хүүгийн нэгдсэн бодлого явуулах, банкуудын заавал байлгах нөөцийг хангуулж ажиллуулах зэрэг аргыг өргөн ашиглаж байна.